

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
БАЙДЛААР ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТОВЧ ТАЙЛБАР

2025.03.20

Мөнхбулаг

Есөнзүйл суманд 2025 оны зөвхөн 01 дүгээр 119 өргөдөл хүлээн авч үүнээс 119 өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүдийн 100% бичгээр ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. 2025 1 дүгээр улиралд онд ирүүлсэн өргөдлүүдээс хамгийн их буюу 71 ирүүлсэн буюу нийт өргөдлийн 59,6%-г Халамжийн үйлчилгээтэй холбоотой өргөдөл эзэлж байна. Мөн нийгмийн даатгалтай холбоотой өргөдөл 20, газар өмчлөх тухай хүсэлт өвөлжөө хаваржааны газар хүссэн өргөдөл нийт 2, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах талаарх өргөдөл 15, ажилд орох, чөлөөлүүлэхтэй холбоотой өргөдөл 8, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 0, Жирэмсний амралт хүссэн 3, бусад агуулгаар 0 өргөдөл тус тус ирж 100 хувь шийдвэрлэн ажиллаад байна.

Сумын албан байгууллагуудаас Засаг даргын Тамгын газарт ажилд орох чөлөөлүүлэх 3, газар хүссэн 2, Эрүүл мэндийн төвд ажилд орох гарахтай холбоотой 2 өргөдөл, Соёлын төвд ажилд орохтой холбоотой 2, Ерөнхий боловсролын сургуульд ажилд орох чөлөөлүүлэхтэй холбоотой 11 өргөдөл, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад чөлөө хүссэн 3 өргөдөл ирэн хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэсэн байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн сумын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

ХЯНАСАН:

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ

МЭДЭЭГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ